



**МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 1/404

Ховд


**Хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд мэргэжлийн ур чадварын Монгол Абилимп-2022 улсын анхдугаар уралдааныг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог хангах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэн олон улсын түвшинд хүргэх зорилготойгоор зохион байгуулж буй уг арга хэмжээнд оролцох багийн үйл ажиллагааны зардалд 1.040.000 төгрөг (нэг сая дөчин мянга) -ийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 1.040.000 төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн төсөл арга хэмжээний 4.5 -д тусгагдсан "Залуучуудын хөгжил" хөтөлбөрөөс тооцож санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Заасаг даргын 2022 оны  
06 дугаар сарын 27-ны өдрийн  
А/404 дүгээр захирамжийн хавсралт

**"МОНГОЛ АБИЛИМП -2022" МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРЫН АНХДУГААР  
ТЭМЦЭЭНД ХОВД АЙМГААС ОРОЛЦОХ БАГИЙН ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Шаардагдах зүйл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Замын зардал	4 хүн 2 талдаа явна -8 билет	110000	880.000
2	Замын хоол	4 хүн явахдаа 1 удаа, ирэхдээ 1 удаа =8	20000	160.000
Нийт				1.040.000

-оОо-